

**МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ХҮМҮҮНШҮҮЛЭХ  
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ЗАРИМ АСУУДАЛ**

**С.Хишигтөгтох  
(ХИС, НХУС-ийн багш)  
МУИС. НШУС**

**Философийн Тэнхмийн докторант  
E-mail: Itsumo\_hanaa@yahoo.com**

**Түлхүүр үгс:** Хүний хөгжил, боловсролын шинэчлэл, боловсрол сургалтын хүмүүнлэг агуулга, оюуны боловсрол, сэтгэлийн боловсрол, хүний мөн чанар, үнэлэмж, мэдлэг, дадал, чадвар, хүмүүшил

**Товч утга:** Байгаль, нийгмийн глобал өөрчлөлттэй холбоотой дэлхийн экологид эрсдэл учирч, хүн бүрийн сэтгэлгээ хүнийсэх болсон зэрэг нь боловсролын өмнө шинэ асуудлыг бий болгож байна. Энэ шинэчлэл боловсролын хүмүүншүүлэх зорилгыг сургалтанд хэрэгжүүлэхийг зүй ёсоор шаардаж байгаа нэг асуудал мөн билээ.

Хүмүүнлэг, энэрэнгүй иргэн төлөвшүүлэхийн тулд ёс суртахууны боловсрол олгох үйл явц нь сургалтаас ангид биш, түүгээр дамжин хэрэгждэг байх зарчим монголын боловсролд дутмаг байна. Багш сурган хүмүүжүүлэгчид сургалтын үйл ажиллагаанд хүмүүншүүлэх үүрэгт чухал ач холбогдол өгдөг байх зарчмыг бодитоор хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага нэмэгдэж байна. Энэхүү сургалтыг боловсронгуй болгох хэрэгцээнд үндэслээд сургалтын агуулга, хэлбэр олон талтай байж, сургалтаар оюуны боловсролоос дутуугүй сэтгэлийн боловсрол эзэмшүүлж, түүний үзүүлэлтийг оюутныг үнэлэх үнэлгээнд зохих ёсоор харгалздаг байх зарчмыг хэрэгжүүлэх нь монголын боловсролын зорилгод нийцэх нэг алхам болно.

**Боловсролын үүрэг, зориулалт, зорилгын тухайд**

Хүн төрөлхтөн бие хүн төлөвшилийн онол практикийн бүхий л асуудлыг философийн хүрээнд дэвшүүлж шийдэж иржээ. Ерөнхий философиос боловсролын философи, сурган хүмүүжүүлэх ухаан тусгаарлаж бие даан хөгжиж эхэлсэн 1960-аад оноос боловсролын философийн судлах зүйл үндсэн асуудлаар эрдэмтдийн дунд судалгаа шинжилгээний асуудлууд хийгдэж эхэлсэн байдаг. Боловсролын философид “боловсрол” гэж юуг ойлгож, хэрхэн тодорхойлох вэ? гэсэн асуудлыг нэг үндсэн судлагдахуунаа болгож байна. Энд боловсролыг тодорхойлох тодорхойлолтоос харвал:

- “Боловсрол олгох хэлбэр олон хувилбартай байж боловсрол нь иргэнийг төлөвшүүлэх үүрэг бүхий үнэт зүйл, нийгэм оршин тогтох, хөгжин дэвжих гол үндэс суурь болно.
- Боловсрол бол шинжлэх ухааны мэдлэг, чадвар, зан суртахууны үнэт зүйл, биеэ авч явах

хэм хэмжээг нийгмийн гишүүдэд эзэмшүүлэх үүрэг бүхий сургалт-хүмүүжлийн бие даасан тогтолцоо

- Боловсрол нь тухайн хүнд нийгэмд ажиллах, амьдрахад нь хэрэглэгдэх хүмүүнлэг ёс суртахуун, хүний эрх, эрх чөлөөний хэм хэмжээнд нийцсэн амьдрах ерөнхий аргын нийлбэр цогц, мэдлэг, чадвар, дадал, үзэл бодол.

- Боловсрол бол хүний эзэмшсэн мэдлэг, ёс суртахуун, шүтлэг, дадал зуршлын нэгдэл. түүнийг нэг үеэс нөгөө үед дамжуулах хэрэгсэл [1.8-9] гэх зэрэг тодорхойлолтууд байна.

Дээрх тодорхойлолтоос үзэхэд боловсрол гэдэгт зөвхөн оюун сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэх ухааны их мэдлэг олгох үйлийг ойлгож болохгүй гэдэг нь харагдаж байна. Боловсрол эзэмших гэдэг нь шинжлэх ухааны аль нэг салбар мэдлэгээр мэргэшсэн мэргэжилтэн байгаад зогсохгүй “тухайн хүнд нийгэмд ажиллах амьдрахад нь хэрэглэгдэх хүмүүнлэг ёс суртахуун, хүний эрх, эрх чөлөөний хэм хэмжээнд нийцсэн амьдрах ерөнхий аргын нийлбэр цогц, мэдлэг, чадвар, дадал, үзэл бодол” [1.8-9] -ийг эзэмших үйл явц, түүний үр дүнг нэрлэж байна. Боловсролыг үндсэн хоёр талт үйл явц гэж үзвэл түүний нэг тал нь ёс суртахуун, зан суртахууны үнэт зүйлийг эзэмших үйл, нөгөө нь мэдлэг, дадал, чадвар эзэмших үйл гэж ойлгож болно.

Эдүгээ монголын боловсролд хэт нэг талд (мэдлэг, чадвартай, сайн мэргэжилтэн болгох) ач холбогдол өгч байгаа нь ирээдүйд оюуны өндөр боловсролтой боловч сэтгэлийн боловсролгүй, зал, мэх, хуншгүй зан чанар, ойворгон хөөргөн чанараар асуудлыг шийддэг болоход хүргэж байна. Тухайлбал, “төрийн албанд сонгогдох боломж нь улс төрчийн ухаан, авьяас билгээр бус, тэр тусмаа зан суртахууны түвшингээр биш, түүний ууттай мөнгөний хэмжээгээр тодорхойлогдох [2.36] бурангүй ёсыг ирээдүйд бид зөвшөөрсөөр байхаас өөр гарцгүй болно. Даяршсан нийгмийн нээлтэй мэдээлэл харилцааны оюунлаг бус үзвэр, зугаа цэнгэлд дулдуйдсан хангагдашгүй материаллаг хэрэглээний ноёрхол,..... өөрийгөө батлан харуулах хүслээ шүтсэн хувиа бодох үзэл,.... зорилгодоо хүрэхийн тулд төрийн засаглалын хөшүүргийг ашиглахын төлөөх эрх мэдлийн тэмцэл,.... байгаль орчныг бохирдуулж, нөөцийг нь шавхахад хүргэдэг санхүүгийн ашиг хөөцөлдөх бодлого... [2.35-38] зэрэг сүйрлээс ухаалгаар өөрийгөө хязгаарлах дотоод сэтгэлийн хүмүүнлэг чанарыг бага балчраас нь эхлэн ухамсарт нь суулгахад л боловсролын жинхэнэ мөн чанар, хүмүүншүүлэх үүрэг, зорилго, зориулалт оршино.

### **Рациональ боловсрол, иррациональ боловсролыг тэнцвэртэй хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага**

Нийгмийн хөгжлийг шинжлэх ухаан, техник, технологийн ололт амжилтаар хэмждэг байсан цаг улирч, эдүгээ аливаа улс орны хөгжлийн чанарыг хүний хөгжлөөр нь тодорхойлох хандлагатай болж байна. “Хүний хөгжил” гэдэгт оюун ухаан, бие бялдрын хөгжил төдий биш, харин бие, сэтгэл, оюуны гэсэн боловсролын цогц хөгжлийг ойлгож байна. Хүн бол хамгийн ерөнхий утгаар “бие, “сэтгэл” “оюун” гэсэн гурван өвөрмөц шинж бүхий цогц зүйлийн нэгдэл байдаг. Хэрэв энэхүү цогц бүрдлийн нэг нь үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрвэл хүний оршихуйн тогтолцоо тэнцвэрээ алдан ажиллаж амьдрах арга ухаан, нөхцөл боломж хомс болно. Цаашлаад хүн гэдэг жинхэнэ мөн чанараа алдах нөхцөл ч үүсэж болно. Энэхүү гурван гол шинжид тулгуурлах байдлаар боловсролыг олгох зарчмыг боловсролын онолчид, философичид чухалчилсан байдаг. Тухайлбал, хүний оюунлаг шинжид тулгуурлан сэтгэхүйг

хөгжүүлэх, шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэх, биеийн чадамжид тулгуурлан чадвар, дадал, туршлага суулгах, сэтгэлийн шинжид тулгуурлан хүмүүншүүлэх гэсэн харилцан уялдаатай зорилгод сургалт боловсролын үйл ажилгаа чиглэх учиртай аж. Ингэж чадвал шинжлэх ухаан, техникжсэн нийгэмд хүнийг хүнээр нь хөгжүүлэх боломж хангагдана. Учир нь боловсрол сургалт, нийгмийн хөгжлийг мэдрэн түүнд зохицон шинэчлэгдэх замаар хүнийг хөгжүүлэх үүрэг зориулалттай. Энэ утгаараа орчин үеийн шинжлэх ухаан техникийн өндөр хөгжил бүхий нийгэмд “боловсролтой хүн” гэдэг ойлголтод мэдлэг, чадвар гэсэн үндсэн үзүүлэлтээс гадна хувь хүний сэтгэлийн мөн чанар төлөвшсөн хүмүүнлэг, оюунлаг, чадварлаг, субъектыг ойлговол зохино.

Орчин үед иргэнд сэтгэлийн боловсролыг төлөвшүүлэх, хүмүүншүүлэх бодлого ихээхэн хомс болсонд судлаачид шүүмжлэлтэй хандаж байна. Тэдний шүүмжлэлээс ишлэхэд “Материаллаг хэрэглээний хязгааргүй өсөлт, техник эдийн засгийн зогсолтгүй тархалт болон нийгмийн өрсөлдөөн дээр суурилсан хөгжлийн техник ашигласан хэрэглэгчийн стратегийн үзэл суртал, практик эцсийн эцэст хүн төрөлхтнийг даяршсан сүйрлийн ирмэг дээр хүргэв. ...” Хүүхдүүд нь компьютер дээр уран гоё ажиллаж, интернетээр аялж байх энэ үед хүн төрөлхтний оюуны соёл илт доройтолд орж, зан суртахууны хөнгөмсөг чанар, логик сэтгэлгээний дадлын хөгжлийн сул дорой, нийтлэг соёлгүй байдлаараа ялгагдаж байна.”[2.] “Өнөөдөр боловсролын шинжлэх ухаанч чанар ихээхэн дэвшилд хүрч, харин боловсролын чухамхүү мөн чанар нь орхигдсон байна. Боловсрол тэрхүү хүмүүнлэг мөн чанараа алдсан болох нь боловсрол сургалт дахь өргөн хүрээтэй зөрчил, бэрхшээл, хямралаас тод харагдаж байна. [3.11] гэжээ.

Дэлхий дахины идэвхтэй техникжилт нь хүн төрөлхтөнд урьд өмнө нь байгаагүй тийм ололтуудыг авчирсан боловч, хүний бүтээсэн техникийн хөгжил эргээд түүний жинхэнэ мөн чанарыг устгаж, сэтгэлийг хоосруулан оршин байгаа эх дэлхийдээ болон нийгэмдээ, хүн хүндээ зүрх сэтгэлгүй механикийн зарчмаар хандахад хүргэжээ. Олон нийтэд нээлттэй хүртээмжтэй болсон мэдээллийн хэрэгслийг хянах боломжгүйн дээр энэхүү шинжлэх ухааны ололт нь бизнес, амжиргааны шинжтэй үйлчилгээ болж хөгжснөөр үйлчлүүлэгчийн тэн хагас нь зөв төлөвшиж амжаагүй хүүхдүүд “PC” тоглоомын донтон болж, эрүүл бие, саруул ухаанаа хөөрхийлөлтэй болгож байгаа билээ. Харамсалтай нь бид өнөөдөр сайхан зүйлийг уншхаасаасаа илүү буруу зүйлүүдийг шимтэн уншдаг болсон зэрэг нь техникийн хөгжлийн хүүхдийн төлөвшил, оюун санаа, бие организмд хор хохирол учруулж эхэллээ.

Тиймээс бид ирээдүйгээ аврахын тулд оюуны хийгээд сэтгэлийн боловсролыг тэнцвэртэй олгох асуудал бидний өмнө тулгамдаж буй чухал асуудал мөн.

### **Боловсролын хүмүүнлэг мөн чанарын тухай философи асуудал**

Хүний оюун санааны гурван үндсэн шинж чанар байдгийг Өрнийн гүн ухаанд оюун ухаан, зан төлөв, сэтгэл зүй (О.Конт, байгаль нийгмийн нөлөөн дор хүний оюун ухаан, сэтгэл зүй, зан суртахуун хэрхэн өөрчлөгдөхийг судлах ёстой) Платон хүн бол бие, сүнс, оюун санааны гэсэн гурван төлөвтэй) гэж заасан байдаг. Түүнчлэн ХХ зууны хүний оршихуйн иррациональ философи чиглэлүүд, сэтгэц ухамсрын тухай сургаалтнуудын үзэлд, сэтгэл бол хүний зан үйлийн дотоод сэдэл, түлхэц, жолоодлого мөн гэсэн баримтлал чухал байр суурьтай байдаг.

Дорнын гүн ухаанд хамгийн ерөнхийгөөр хүн бол оюун ухаан, бие, сэтгэл гурвын цогц хэмээн тодорхойлдог. Күнзийн сургаалтнууд, Буддийн сургаалтнууд, мөн монголын гүн ухааны сургаалд ч хүнийг хөгжүүлэх үйлд сэтгэлийн мөн чанар гол үүрэгтэй болохыг харгалзаж иржээ. Тухайлбал: Күнзийн сургаалд хүнлэг чанарын талаар олонтаа бичсэн. Тэрээр “Зөвхөн хүнд л бусдыг өөр шигээ хайрлах мэдэрхүй байдаг. Хүнийг хүн болгож байгаа гол чанар бол хүнлэг ёс юм..., хүнлэг зан чанар нь хүний оршихуйн гол үндэс..., хүнлэг ёсыг хэрхэн удирдлага болгосноос шалтгаалж хүмүүсийн аж байдал янз бүр байдаг. Түүнчлэн хүнлэг ёс нь хувь хүний

төдийгүй, нийгэм улс төр эдийн засгийн бүхий л асуудлыг шийдвэрлэх түлхүүр үндэс болдог” [4.22] гэх зэргээр хүний хүмүүнлэг чанар, ёс суртахууныг философи баримтлалынхаа гол асуудал болгон тавьсан байдаг.

Дорнын эрдэмтэд хүний төрөлх чанар бол сэтгэл эвдрээгүй төрөлхийн язгуур байдал, харин нийгэм соёлын нөлөөнд хүний зан чанар эвдэрч хүн чанараа алдаж болдог учраас хүний байгалийн сайн шинжийг хэвээр нь хадгалан хөгжүүлэхэд боловсрол сургалт чухал үүрэгтэй гэж үзсэн байдаг. Тухайлбал, Хятадын гүн ухаантан Мэнзийн үзлээр хүн төрөлхийн сайхан сэтгэлтэй, нийгэм соёлын нөлөөнд орсноор муу үйлийг хийх сэдэлтэй болдог гэж үзсэн. Тэрээр, “Хэрвээ хүн муу үйл хийлээ гэхэд тэр нь үүсмэл шинж чанартай, нүдээр үзэж чихээр сонссон муу үйлийн нөлөө байдаг. Муу үйлийн нөлөөнөөс хүний сэтгэл санааг хамгаалах хэрэгтэй. гээд цааш нь боловсролын үүргийг онцлохдоо, “зөвхөн эрдэмтэн хүмүүс байнгын хөрөнггүй ч гэсэн нэгэн хэвийн сэтгэлгээтэй байдаг, харин боловсролгүй хүн бол байнгын хөрөнггүйгээр тэд нэгэн хэвийн сэтгэлтэй байдаггүй” [4.33] гэж үзжээ. “Буддын гүн ухаанд хүнд байдаг буруу сэтгэлийн 80 араншин, нисваанисын хорыг дарж сэтгэлээ ариусгаж байхыг заасан. Буруу сэтгэлийн язгуурын 6 нисваанис нь мунхаг буюу эрдэмгүй байдал, шунал, уур омог, буруу үзэл буюу хүнийсэл, ичгүүргүй буюу ёс суртахуунгүй зэрэг сэтгэлийн гэмийг гэтэлж гэмээнэ оюуны соёлыг олно гэж үздэг байв.” [3.19]

Хүнийг хөгжүүлэх, төгөлдөржүүлэх тухай дээрх сургаалуудаас харахад хүний сэтгэлийн муу чанарыг сургалтаар засаж, нийгэм соёлын сөрөг талаас үүдсэн аливаа сэтгэлийн гэмээс өөрийгөө ангижруулж чадах, хүмүүнлэг сэтгэл, ёс суртахууны боловсролыг олгох тухай асуудал хүний оршихуй хийгээд нийгэмд чухал байр сууртай болохыг хүн төрөлхтний сэтгэлгээнд эртний үеэс анхаарч ирсэн нь үзэгдэнэ.

Хүний нийгмийн өөрчлөгдөн шинэчлэгдэх замаар урагшлах зайлшгүй хуулийн дор хүний оюун ухаан, сэтгэл зүй, зан суртахуун ертөнцийг үзэх үзэл ч түүний аясаар өөрчлөгдсөөр байдаг. Түүхэн үүргээ гүйцэтгэсэн бүх зүйл хоцрогддог жамтай ч хүн хөгжхийн хэрээр хоцрогдож үл болох ганц зүйл бол хүний мөн чанар буюу сэтгэлийн шинж мөн. Бидний ирээдүйнхний хийж бүтээх техник, технологи орчин үеэс хэд дахин илүү арга ухаантай, боловсронгуй болж бидний үеийн арга ухаан хоцрогдож болно.

Гэвч “хүн гэж хэн бэ?” гэдгийг тодорхойлоход орхиж болошгүй чухал шинжийн нэг бол яах аргагүй сэтгэл зүрх мөн. Хүн бол оюун ухаант амьтан, мөн сэтгэл зүрхт амьтан. Оюун ухааны ачаар шинжлэх ухааны өндөр дэвшилд хүрээд ирэхийн цагт хүнийг хэт техник сэтгэлгээ ноёлох болж, эргээд сэтгэлийн мөн чанарыг хоосруулах аюултай. Даяаршил, техникийн хурдацтай хөгжилтэй зэрэгцэн түүнийг ашиглах хүний хэрэгцээ улам бүр өндөрсөж байна. Энэ хэрэгцээнээс үүдсэн хүний хөгжлийг боловсрол сургалтаар хангахын зэрэгцээ, сэтгэлийн мөн чанарыг хэвээр нь хадгалж, хүнийг хүнээр нь хөгжүүлэхэд боловсролын хүмүүнлэг мөн чанарын агуулга оршино. Боловсролыг хүмүүнлэг агуулгатай болгож, түүнийг хэрэгжүүлэхийн тулд, Аль ч чиглэлийн мэргэжлийн сургалтанд хүмүүнлэгийн ухааны хичээлүүдийг заавал судлах хичээл болгох.

\* Эдгээр хичээл нь суралцагчдын хүмүүжил төлөвшилд нөлөөлж чаддахуйц үр дүнтэй агуулга бүхий, заах арга зүй нь амьдралд уялдсан прагматик үр дүнтэй байх.

\* Энэ чиглэлийн хичээлээр оюутныг үнэлэхдээ суралцагчийн зан суртахууны төлөвшил, аливаад хандах хандлага, сэтгэлийн мөн чанарыг харгалзан, түүнд гарсан бодит ахиц, өөрчлөлтөөр нь үнэлдэг байх.

\* Аль ч мэргэжлийн сургалтын үйл явцад хүмүүнлэгийн чиг баримжааг ямагт харгалздаг байх шаардлагатай. Түүнчлэн их дээд сургуулийн бүх мэргэжлийн чиглэлийн сургалтанд оюутныг үнэлэх үнэлгээнд тэдний төлөвшил, хүмүүншлийн үзүүлэлтийг зохих хэмжээнд оруулж үнэлж дүгнэдэг байх зарчмыг хэрэгжүүлэх зэрэг туршилтуудыг хийж

үр дүнтэй эсэхийг турших хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна.

Сэтгэлийн мөн чанараа гээж гэмээнэ хүн бүтээсэн хөгжлийнхөө боол нь болж, хүний нийгэм тэнцвэрээ алдан өөрийгөө устгахад хүрэх аюултай.

### НОМ ЗҮЙ

1. Ичинхорлоо.Ш. Боловсролын философи үзэл,санаа: эрт ба эдүгээ. УБ., 2011
2. Иванов.А.В, Фотиева.И.В, Ёс суртахуун-оюун ухаант мандлын соёл иргэншил: үндэслэл хэтийн төлөв УБ.,2011
3. Пүрэв.О. Монголын боловсрол сургалтыг хүмүүншүүлэх онол арга зүйн зарим асуудал. УБ.,2007
4. Дарьхүү. Р. Эрдэнэбаяр. Г. Философийн түүх. I дэвтэр. УБ., 2006
5. Нэмэхжаргал. Т, Боловсролын философийн үзэл баримтлал-арга зүйн асуудал. УБ., 2009.
6. Тунгалаг. Д. Ёс зүй. УБ., 2004
7. Ичинхорлоо. Ш. Сургалтын арга зүйн шинэчлэл. УБ., 2008

### RESUME

*The process that allow moral education is not distinct and the principle is deficient in Mongolia which to be realized verminous it for humanitarian and charitable citizen pedagogics.*

*Demands and claims are growing regularly which principles to be realized in right that teachers and pedagogues to give most importance to be realized learners in activity training. Moral education is formal in secondary education and university. Young generation needs educate moral and humanism.*